

**“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 06 дугаар сарын 14-ны өдөр

Улаанбаатар хот

БҮРТГЭЛ: 10:00-10:40

НЭЭЛТ: “Газар шим ХК Үйлдвэр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 10:42 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энх тайвны өргөн чөлөө, 17, 14240, Блю ский цамхаг, Эмералд танхимд эхлэв.

Хурлын дарга П.Нямдорж: Хуралд хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчид, ТУЗ-д нэр дэвшигч нартаа энэ өдрийн мэндийг хүргэж, хурлын үйл ажиллагааг эхлүүлж, Хурлын ирцийн мэдээллийг танилцуулахыг Тооллогын комисст даалгав.

Тооллогын комиссын дарга С.Батчимэг: Өнөөдөр хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигч нарт энэ өдрийн мэндийг хүргэе. Газар Шим Үйлдвэр ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссоос тогтоол гарч байна. 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдөр дугаар 01, Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4 дэх хэсэг, 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ НЬ:

Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит бус хуралд 2023 оны 05 дугаар сарын 20-ны тасалбар болгосон өдрийн байдлаар компанийн нийт гаргасан 1,198,113,207 ширхэг энгийн хувьцаанаас 1,004,937,437 ширхэг буюу 83,8% хувийг эзэмшиж байгаа 28 хувьцаа эзэмшигчид биеэр оролцож, 7,920,394 ширхэг буюу 0,7% хувийг эзэмшиж байгаа 1 хувьцаа эзэмшигч итгэмжлэлээр оролцсон нь компанийн нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 1,012,857,831 ширхэг буюу 84,5% хувийг бүрдүүлж байгаа учраас Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Тооллогын комиссын дарга С.Батчимэг, Гишүүд А. Тайван, М. Даваажав, Д.Хишигсүрэн

Хурлын дарга П.Нямдорж: Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц маань Компанийн тухай хуулийн шаардлагыг хангаж, хүчин төгөлдөр болсон тул хурлын үйл ажиллагааг батлагдсан дэгийн дагуу цааш нь үргэлжлүүлэе. Хурлын үйл ажиллагааг албан ёсоор нээж өгнө үү хэмээн Газар Шим Үйлдвэр ХК-ийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал Ц.Ганбатыг индэрт урьж байна.

Гүйцэтгэх захирал Ц.Ганбат: Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа нийт хувьцаа эзэмшигчдэд мэндчилгээ дэвшүүлээд, Компанийн танилцуулга болон компанийн нэмж гаргасан хувьцааг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагааны хэрэгжилт, үр дүн болон уг ажиллагаатай холбоотой гарсан зардлын тайлангийн танилцуулгыг хийлээ.

“Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэж, сайн сайхан бүхнийг хүсье ээ. Миний бие нь 1999 оноос хойш Газар шим ХХК-г үүсгэн байгуулж одоог хүртэл удирдан явуулж байна. Компанийн үүсэл хөгжил болон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн процессын талаар та бүхэн мэдээлэлтэй байгаа гэдэгт итгэлтэй байна. Тиймээс компанийн нэмж гаргасан хувьцааг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагааны хэрэгжилт, үр дүн болон уг ажиллагаатай холбоотой гарсан зардлын тайланг танилцуулъя.

Компани нийт хувьцааныхаа 16,54% буюу 198,113,207 ширхэг хувьцааг, нэг бүрийг нь 53 төгрөгөөр, 50 хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдэх 50 хувийг олон нийтэд санал болгож, нийт 10,5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 2,879 хөрөнгө оруулагчаас 216,380,683 ширхэг буюу 11,468,176,199 төгрөгийн үнийн дүн бүхий 2,952 захиалга

Хуудас 1 - 8

ирүүлсэн бөгөөд стратегийн хөрөнгө оруулагчдын захиалга болон олон нийтээс ирүүлсэн 2,000 ширхэг хүртэлх хувьцааны захиалгыг 100 хувь биелүүлж, үлдсэн үнийн дүнг 84.8 хувиар хувь тэнцүүлэн хуваарилалтыг хийсэн. Энэ хугацаанд СЗХ болон бусад холбогдох эрх бүхий байгууллагуудад холбогдох тайлан мэдээнүүдээ цаг тухай бүрд нь өгч ажиллаж байна.

Компани олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөрөө Хүнсний ногоон зоорь, тоног төхөөрөмж шинэчлэлт, Бүтээгдэхүүн хөгжүүлэлтүүдийг хийхээр төлөвлөсөн бөгөөд, гүйцэтгэлийн хувьд дараах байдалтай байна.

- ✚ Хүнсний ногооны зоорь: Ногооны зоорины барилга болон тоног төхөөрөмжийн үнийн саналыг дахин БНХАУ-ын 4 компани, ХБНГУ-ын 2 компаниас авсан. Ногооны зоориноос гадна анхан шатны боловсруулах үйлдвэр, гүн хөлдөөх агуулах, нэрийн дэлгүүр зэргийг нэмж бүтээн байгуулахаар төлөвлөж байна.
- ✚ Тоног төхөөрөмжийн шинэчлэлт: БНХАУ болон Европын орнуудаас тоног төхөөрөмжийн судалгааг хийж байна. Бэлтгэх дамжлага буюу анхан шатны боловсруулалтын үйл ажиллагааны автоматжуулалт нь өртөг өндөр, үр ашиг багатай байхаар байна. Зарим зүйлсийг өөрсдөө дотоодын нөөц бололцоогоо ашиглан хийх арга замыг эрэлхийлж байна.
- ✚ Бүтээгдэхүүн хөгжүүлэлт: Ногооны нухшийг зах зээлд нийлүүлж эхэлсэн. Жимсний нухаш, хүүхдийн тэжээл үйлдвэрлэх жор, найрлагыг тодорхой болгож, үйлдвэрлэлд шилжүүлэхэд бэлэн болоод байна. Сав баглаа боодол, түүхий эд, савлах тоног төхөөрөмж худалдан авч суурилуулснаар үйлдвэрлэж эхлэх болно. Сав баглаа боодлын загвар дизайныг ярилцаж байгаа. Майонез болон кетчуп үйлдвэрлэх туршилт, судалгааг хийж байна.

Компанийн 2022 оны 1-р улирлын санхүүгийн үзүүлэлтүүд(борлуулалтын орлого, нийт ашиг, цэвэр ашиг, Ebitda, татвар төлөлт, ажилтны тоо)-ийг IPO хийсний дараах буюу 2023 оны 1-р улиралтай харьцуулахад бүгд өссөн дүнтэй байна.

Хурлын дарга П.Нямдорж: Хурлын үйл ажиллагааг албан ёсоор нээж, компанийн танилцуулга, компанийн нэмж гаргасан хувьцааг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн танилцуулга мэдээллийг өгсөн Гүйцэтгэх захирал Ц.Ганбат-даа баярлалаа.

Одоо дэгийн дагуу хурлаар дараах 3 асуудлыг хэлэлцэн батлахаар байгаа. Үүнд:

- Нэг. ХК-ийн дүрмийн төслийг хэлэлцэн батлах;
- Хоёр. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, батлах;
- Гурав. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын төсвийг батлах;

Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр танилцуулга явна. Та бүхэнд тараагдсан саналын хуудаст хэлэлцэх асуудал тус бүрээр саналаа өгөөд, энэ саналын хуудасны хайрцагт хийгээрэй. ТУЗ-ийн гишүүдийг сонгох кумулятив аргын талаар хурлын зохион байгуулалтын комисс, тооллогын комиссын ажилтнууд мэдээлэл, заавар өгөөд явах болно. Асууж тодруулах зүйлс байвал энэ зааланд байгаа хурал зохион байгуулах ажлын хэсгийнхэнтэй шууд холбогдоорой.

За Хурлын дэгийн дагуу эхний хэлэлцэх асуудал болох КОМПАНИЙН ДҮРМИЙН ТӨСЛИЙГ БАТЛАХ-тай холбоотой мэдээллийг өгье.

Хурлын материалтай хамт та бүхэнд тараагдсан ХК-ийн дүрмийн төсөлд техникийн цөөн хэдэн засвар орсон байгааг та бүхэнд танилцуулъя.

- ✓ Дүрмийн төслийн 2.3 дахь хэсэгт хаягийн мэдээллийг тодорхой зааж оруулах саналтай;
- ✓ Дүрмийн төслийн 5.5 болон 7.8 болон 7.9 дэх хэсгүүд утга агуулга ижил байсан тул 7.9 дэх хэсгийн зохицуулалтыг үлдээгээд бусад хэсгийг хасах саналтай ;

- ✓ Дүрмийн төслийн 7.10 дэх хэсэгт өөрчлөлт оруулан шинэчлэн найруулах саналтай;
- ✓ Дүрмийн төслийн 8.6.4 болон 8.6.5 дахь хэсэг Компанийн тухай хуульд зааснаар ТУЗ-ийн эрх хэмжээний асуудал, ТУЗ их хэмжээний хэлцлийг санал нэгтгэйгээр, сонирхлын зөрчилтэй хэлцлийг сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхын саналаар батлаагүй бол ХЭХ-аар хэлэлцүүлэх эрхтэй учир хасах саналтай;
- ✓ Дүрмийн төслийн 11.1 дэх хэсэгт компанийн эрх бүхий албан тушаалтнуудыг нэг бүрчлэн албан тушаалаар зааж оруулсан байсныг Компанийн тухай хуулийн 84.1-т зааснаар тодорхойлж оруулах саналтай;
- ✓ Дүрмийн төслийн 14-р бүлгийн агуулга 7-р бүлгийн агуулгатай давхардсан байх тул 14-р бүлгийг хасах саналтай;
- ✓ Дүрмийн төслийн 16.4 дэх хэсэгт "...татварын алба гэснийг СЗХ, Монголын хөрөнгийн бирж..." гэж өөрчлөн найруулах саналтай;

Хурлын дарга П.Нямдорж: Та бүхэн дүрмийн төсөл болон төсөлд оруулсан техникийн саналуудтай холбоотой нэмж тодруулах зүйлс байвал хэлнэ үү. Санал, тодруулга байхгүй бол хурлын хоёр дахь хэлэлцэх асуудал болох ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ, ТОМИЛОХ асуудлын танилцуулгадаа оръё. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарласан тогтоолд тусгагдсаны дагуу 2023 оны 05 сарын 25-ны өдөрт багтаан Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшихээр танилцуулга, материалаа илгээсэн гишүүдийн мэдээллийг дэлгэцээр харуулъя.

Төлөөлөн удирдах зөвлөлд нийт 9-н гишүүн сонгогдох ёстой ба үүнээс 6 ердийн гишүүн, 3 хараат бус гишүүн сонгогдох ёстой. Үүнд-

- ✓ Ердийн гишүүнд нэр дэвшихээр 6 хүн мэдүүлэг, материалаа ирүүлсэн;
- ✓ Хараат бус гишүүнд нэр дэвшихээр 6 хүн мэдүүлэг, материалаа ирүүлсэн байна.

Ердийн нэр дэвшигчид:

1. Ц.Ганбат
2. Ш.Алтанбагана
3. Ц.Төгсөө
4. З.Байгалмаа
5. Д.Сэргэлэн
6. П.Нямдорж

Хараат бус гишүүнд нэр дэвшигчид:

1. О.Эрдэнэдалай
2. Б.Анхбаяр
3. В.Ганзориг
4. Н.Отгонбаяр
5. Ч.Баяртуул
6. Б.Ганбаяр

ТУЗ-ын гишүүнд нэр дэвшигч нарыг тайзан дээр урьж байна. Та бүхэн товчхон өөрсдийн танилцуулга, мэдээллээ хуралд оролцогч хувьцаа эзэмшигч нарт өгөхийг хүсье.

Нэр дэвшигчид өөрсдийгөө товч танилцуулж, Газар шим ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвших болсон зорилгоо танилцуулав.

- ✓ С.Ганбат нэр дэвшигч товч танилцуулгаа хийж, хамтдаа төлөөлөн удирдах зөвлөлөө сонгож Газар шим ХК-г улам өргөжүүлж илүү боловсонгүй болгоход хувь нэмэр оруулаарай гэж хүсэж байгаа тухайгаа хэлэв.

- ✓ Ц.Төгсөө нэр дэвшигч товч танилцуулгаа хийж, Газар шим ХК-н үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд одоогоор бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг илүү боловсронгуй болгох, үйлдвэрийн алба удирдан ажиллаж байгаа талаар дурдав.
- ✓ З.Байгалмаа – 1999 онд Отгонтэнгэр их сургуулийг Эрх зүйч мэргэжлээр сурч төгссөн, одоогоор Захиргаа хүний нөөцийн албаны захирлаар ажиллаж байгаа тухайгаа ярих.
- ✓ Ш.Алтанбагана- Сүүлийн 20 орчим жил мэргэжлээрээ ажиллаж 10 гаруй компанид төлөөлөн удирдах зөвлөлд ажиллаж байна.
- ✓ Д.Сэргэлэн- 2020 онд Маркетинг борлуулалтын албаны даргаар ажилладаг.
- ✓ Б.Анхбаяр- 2013 оноос хойш хүний нөөцийн зөвлөхөөр ажиллаж байгаа.
- ✓ Ч.Баяртуул-Дэлхийн банкны хуурай боомт хөгжүүлэлтээр ажиллаж байгаа, хэд хэдэн компанид хараат бус гишүүнээр ажиллаж байгаа
- ✓ Н.Отгонбаяр- Бизнесийн болон нийгмийн салбарт ажиллаж байсан. Одоогоор Бизнесийн салбарт ажиллаж байгаа. UB сав-н үүсгэн байгуулагчдын нэг. Одооч мөн ажилласаар байгаа.
- ✓ Б.Ганбаяр- 2003 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа, АПУ ХХК, сүү хувьцаат компанид ажиллаж байсан.
- ✓ О.Эрдэнэдалай- хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд өөрийн биеэр ирж чадаагүй.
- ✓ В.Ганзориг- хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд өөрийн биеэр ирж чадаагүй.
- ✓ П.Нямдорж- Монголын хөрөнгийн биржид 10 гаруй жил ажиллаж байгаа. Ажлын туршлага 2015 оноос одоог хүртэл Бат солишн ХХК удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байгаа.

Хурлын дарга П.Нямдорж: Нэр дэвшигч нараас асуух асуулт, нэмэлт тодруулга байна уу? Байхгүй бол Хурлын гуравдах хэлэлцэх асуудал болох байхгүй гэсний дагуу **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ, ТӨСВИЙГ БАТЛАХ** асуудлын дэлгэрэнгүй танилцуулга, тооцооллын задаргааг танилцуулъя.

№	Төсөв	1 хүний (1 удаа)	Давтамж	Нийт	Гишүүдийн тоо	Нийт
Цалин						
1	Цалин үндсэн ТУЗ-н дарга	1,500,000.00	12.00	18,000,000.00	1.00	18,000,000.00
2	Цалин үндсэн ТУЗ-н гишүүн	1,000,000.00	12.00	12,000,000.00	8.00	96,000,000.00
Урамшуулал						
3	Хорооны даргын нэмэгдэл	200,000.00	12.00	2,400,000.00	4.00	9,600,000.00
4	Даатгал	200,000.00	1.00	200,000.00	9.00	1,800,000.00
Бусад						
5	Бичиг хэргийн зардал	100,000.00	4.00	400,000.00	-	400,000.00
6	ТУЗ-ын хурлын зардал	200,000.00	4.00	800,000.00	-	800,000.00
7	Уулзалт, тусгай арга хэмжээ, бусад	800,000.00	4.00	3,200,000.00	-	3,200,000.00
Жилийн нийт төсөв						129,800,000.00

Хурлын дарга П.Нямдорж: Та бүхэнд ТУЗ-ийн төсвийн задаргаанаас нэмж тодруулах асуудал, асуултууд байвал хэлнэ үү? Хувыцаа эзэмшигчдээс асуулт, тодруулга байхгүй бол саналын хуудас бөглөх зааврын дагуу хэлэлцэх асуудал тус бүрээр саналаа өгөхийг хүсье.

Яг одоо цаг 11:40 минут болж байна. Та бүхэн саналаа өгсөн бол тооллогын комисс саналын нийт дүнг гаргатай 40 минут түр завсарлаж, цай кофе уухыг хүсье.

ХУРАЛ ТҮР ЗАВСАРЛАВ.

Тооллогын комиссын дарга С.Батчимэг: Санал хураалтын дүн мэдээг танилцуулав.

Газар Шим Үйлдвэр ХК-ийн ээлжит бус хурлын тооллогын компанийн тогтоол гарч байна. 2023 оны 06-р сарын 14-ний өдөр, дугаар № 02, Улаанбаатар хот, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгсөн саналын нэгдсэн дүнгийн талаар”

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйл 67.3 дах хэсгийг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. “Газар Шим Үйлдвэр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудалд хувьцаа эзэмшигчид доорх байдлаар санал өгсөн тухай хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.

№	Хэлэлцсэн асуудал	Өгсөн санал	Зөвшөөрсөн	Татгалз сан	Түдгэлзсэн	Хүчин гүй	Хувь
1	Компанийн дүрмийн төслийг хэлэлцэн батлах тухай;	1,012,857,831	1,012,857,831	-	-	-	100%
2	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, батлах тухай;	1,012,857,831	1,012,830,426	-	-	27,405	99,9%
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг батлах тухай;	1,012,857,831	1,012,857,831	-	-	-	100%

Хоёр. ТУЗ-ийн гишүүдийг сонгох

№	Нэр дэвшсэн гишүүн	Нийт өгсөн саналын эрхийн тоо	Хүчингүй саналын эрхийн тоо
ТУЗ-ийн ердийн гишүүнийг сонгох санал хураалт			
1.	Цээпэлийн Ганбат	995,029,997	3,000
2.	Шийтуугийн Алтанбагана	1,028,912,641	-
3.	Цээпэлийн Төгсөө	993,666,832	3,000
4.	Занаширын Байгалмаа	1,083,071,732	6,000
5.	Дүгэржавын Сэргэлэн	983,123,979	-
6.	Пүрэвсүхийн Нямдорж	997,435,441	6,000
ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох санал хураалт			
7.	Батсуурийн Ганбаяр	531,751	-
8.	Ванчигийн Ганзориг	1,007,324,424	1,405
9.	Намсрайдоржийн Отгонбаяр	719,930	1,000
10.	Чимэд-Очирын Баяртуул	1,007,363,521	5,000
11.	Одхүүгийн Эрдэнэдалай	1,007,388,649	2,000
12.	Батбаярын Анхбаяр	11,124,177	1,000

Гурав. Саналын хуудас болон нэгтгэсэн дүнгийн тухай энэхүү тогтоолын нэг хувийг компанийн архивд хадгалуулахаар шилжүүлсүгэй.

Тооллогын комиссын дарга, гишүүд;

Хурлын дарга П.Нямдорж: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолыг танилцуулъя.

**“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 06-р сарын 14-ний өдөр

№01

Улаанбаатар хот

Компанийн дүрмийн төслийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын тогтоол №2-г тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ТОГТООХ НЬ:**

- Нэг. ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК-ийн (цаашид “компани” гэх) дүрмийг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
- Хоёр. Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга болон Гүйцэтгэх захирал /Ц.Ганбат/ нарт үүрэг болгосугай.
- Гурав. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд зохих журмын дагуу холбогдох бүртгэлийн байгууллагад хүргүүлж, бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Ганбат/, Өмгөөллийн “Сноу Хилл Консалтанси” ХХН-ийн хуульч А.Солонго, А.Тайван нарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага хариуцсан захирал албан тушаалтай /З.Байгалмаа/ нарт тус тус үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА П.НЯМДОРЖ